



АРХАНГАЙ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН АЛБАН  
ДААЛГАВАР

2018 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 02

Цэцэрлэг

Статистик бүртгэл, мэдээллийн  
үнэн бодит бүртгэл, чанарыг сайжруулах тухай

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 11 сарын 27-ны өдрийн 450 дугаар тушаалын биелэлтийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, мэдээ, мэдээлэлд тавих хяналтыг сайжруулах зорилгоор ЭМГ-ын даргын 2018 оны 3-р сарын 15-ны өдрийн Нэгдсэн эмнэлгийн статистикийн бүртгэл мэдээллийн үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийх ажлын удирдамжийн дагуу эрүүл мэндийн мэдээ, мэдээллийн чанар, бүртгэлийн болон тайлангийн маягтын хөтлөлтөд гарсан алдаа зөрчилд үндэслэн Нэгдсэн эмнэлгийн даргад ДААЛГАХ нь:

1. Эрүүл мэндийн статистикийн мэдээллийн талаарх авах арга хэмжээний тухай ЭМСайдын 2013 оны 11 сарын 27-ны өдрийн 450 дугаар тушаалын биелэлтийн хэрэгжилтийг эрчимжүүлэн, мэдээллийг үнэн, зөв бүртгэн ажиллах аяныг өрнүүлж, тасаг, нэгжийн эрхлэгч эмч, менежерүүд, албадын дарга нарт албан даалгавар хүргүүлж, биелэлтийг тооцон ажиллах

2. Удирдлагын болон чанарын алба статистикийн албаны бүртгэл мэдээллийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг сайжруулан, мэдээллийн үнэн бодит байдалд хяналтыг сар бүр хийж байх

3. Эмнэлгийн тасаг нэгжүүдэд эрүүл мэндийн статистик бүртгэл мэдээллийн талаарх дотоод хяналтыг чанаржуулж үр дүнтэй хийх, асуудлыг шийдвэрлэж, эргэх хяналтыг сайжруулах

4. Анхан шатны нэгжид хөтлөгдөж буй анхан шатны маягтын бүртгэл мэдээлэлд тавих өдөр тутмын хяналтыг сайжруулах

5. Сар, улирал, жилийн мэдээ, мэдээллийн уялдаа холбоо, үнэн бодит, шуурхай байдлыг хангах

6. Анхан шатны маягт хөтлөлт болон өвчлөл, нас баралт, төрөлтийн бүртгэл, мэдээллийн талаар эмч, мэргэжилтэнүүдэд дотоод сургалтыг зохион байгуулж, мэдлэгийг сэргээх

7. Анхан шатны маягтуудыг цаг хугацаанд нь үнэн зөв стандартын дагуу хөтөлж, мэдээ тайланг цаг тухайд, үнэн зөв гаргасан эсэхэд удирдлагын зүгээс хатуу анхаарч, хариуцлага тооцох

8. Эрүүл мэндийн статистик мэдээллийн талаар авах арга хэмжээний тухай ЭМСайдын 2013 оны 450 тоот тушаалын хэрэгжилтийг зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцон ажиллах

9. Албан даалгаврыг хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, гарсан үр дүнгийн талаарх тайланг 2018 оны 6 сарын 15-ны дотор ЭМГ-т ирүүлэхийг Нэгдсэн эмнэлгийн даргад даалгаж байна.

ДАРГА



Р.ГАНДИЙМАА